

Монголын бурханы шашинтнууд дэлхийн тавцанд  
гарч ирсэн нь

**Ч.Дамбажав**

Дашчойлин хийдийн хамба лам  
Магистр, докторант

**Түлхүүр үг:** шашинтнуудын гадаад харилцаа, хамтын ажиллагаа, олон улсын шашны байгууллагууд:

1990 оноос өмнөх үед Монголд бурханы шашны ганц хийд ажиллаж байсныг бид бүгд мэднэ. Монголын бурханы шашинтан нар, түүний тэв Гандантэгчэнлийн хийдийн үйл ажиллагааны нэг чухал чиглэл нь гадаад харилцааны ажил байв. Тус хийдийн гадаад үйл ажиллагаа нь бусад орны буддистуудтай найрсаг харилцаа тогтоон хөгжүүлэх, бүх нийтийн энх тайван, эв зохицлын үйлсэд идэвх гарган оролцож, хувь хандиваа нэмэрлэхэд чиглэж байсан юм.

Ер нь бурханы шашинтны гадаад харилцаа нь улс орны нийт гадаад бодлогын чиглэл, олон улсын харилцааны хөсөг болж явахаас аргагүй байсан нь мэдээж хэрэг билээ. БНМАУ эхний үед зөвхөн ЗХУ-тай харилцаа бүхий, гадагшаа харах ганц цонхтой байсан бол 40-өөд оны эцэс, 50-иад оноос олон улсын тавцанд гарч эхэлсэн байна. Монгол улсын гадаад харилцаа нь юуны өмнө ардын ардчилсан (социалист) орнуудад чиглэж байсан нь шашны гадаад харилцаанд мөн нөлөөлжээ. Монгол улстай харилцаа бүхий орнуудаас бурханы шашинтай нь манай урд хөрш БНХАУ байв.

Гандан хийд БНХАУ-ын бурханы шашинтан нар, тухайлбал Өвөр Монголын буддистуудтай холбоо тогтоож, хамтын ажиллагааг эхэлж байв. Хятадын Бурханы шашинтны холбооны дарга тэргүүтэй төлөөлөгчид 1957 онд Монголд айлчилж, тэдний хүсэлтийн дагуу Монголоос зарим ном судар, тухайлбал монгол мэргэдийн зохиол сумбуунаас Хятадад бэлэглэж байсан байна.

Бурхан багшийн энх амгалан, эв зохицол, энэрэнгүй үзлийн сургаалаар удирдуулсан монголын бурханы шашинтнууд улс хоорондын энх тайвны төлөө, дайны хор аюулын эсрэг нийтийн тэмцэлд оролzon, энэхүү буянтай үйлсэд хувь нэмрээ оруулахыг гадаад харилцааны нэг гол зорилтоо болгож ирсэн юм. Олон улсын энх амгалангийн хурал, чуулганд монголын бурханы шашинтны төлөөлөгчид байнга оролцож, хүн төрөлхтний амар амгалан аж төрөхийн төлөө дуу хоолойгоо нэгтгэж, мөн гадаад орнуудаас

## МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

буддын шашны болон бусад энхийг эрхэмлэгчдийн төлөөлөгч, зочдыг олноор хүлээн авч байв. Тухайлбал, Бурхан багшийн мэндэлсний 2500 жилийн ойд зориулан Энэтхэгт 1956 онд зохион байгуулсан олон улсын бурханы шашилнуудын чуулга уулзалтад монголын бурханы шашилтын төлөөлөгчид оролцож, дэлхийн бурханы шашилтан нарын хамтын үйлсэд дуу хоолойгоо нэгтгэн, холбоо харилцаа тогтоосон нь манай орны бурханы шашилнуудын гадаад харилцаа өргөжин, хөгжихөд чухал алхам болсон байна.

1950-иад оны эцсээр Гандан хийдэд Балбын бурханы шашилтын нэрт зүтгэлтэн их ламтан Амритананда, Японы синто шашны том зүтгэлтэн, эрхэмсэг Т.Мияке нарын зэрэг шашны нэрт зүтгэлтнүүд айлчилж, энх тайвны болон шашин номын хамтын ажиллагааны талаар санал солилцож байв.

60-аад оноос Монголд ирсэн гадаадын, япангуяа өрнөдийн орнуудын томоохон төлөөлөгчид гол төлөв Гандан хийдэд зочилж, Монголын шашны төвийг үзэж тагнилцахын зэрэгцээ хийдийн хамба ламтай уулзаж ярилцдаг байжээ. Энэ нь Гандан хийдээс өөрийн орны болон гадаад гүрнүүдийн бодлого, үйл ажиллагаатай танилцах, гадаад харилцаагаа өргөтгөхөд багагүй нөлөөлжээ.

Монголын бурханы шашилнууд Бурхан багшийн сургаалыг мөрдлөг болгон хувь хүмүүсийн харилцаанд ч, айл гэрийн дотор ч, улс гүрнүүдийн хооронд ч энх амгалан, эв зохицонгуй байхыг эрхэмлэж, дэлхий дахины энх тайван, эн тэргүүнд Ази тивийн энх амгалангийн үйлсэд идэвх чармайлттай оролцож, хувь нэмрээ оруулахыг ямагт эрмэлзэж байсан билээ. Түүний нэг тод илрэл, чухал үр дүн нь Монголын бурханы шашилтын тэргүүн, хамба лам Самиагийн Гомбожавын санаачилга, чармайлтаар Ази тивийн бурханы шашилнуудын энхийн хамтын байгууллага бслсон Азийн буддистуудын энх тайвны бага хурлыг үүсгэн байгуулж, хөгжүүлж ирсэн явдал мөн. Энэтхэг-Хятадын хойгт дайн болж байсан хүнд үе, тухайлбал 1969 онд шашин нэгт нэгэн номын вьетнам нөхдийнхөө зовлон зүдгүүрийг хуваалцан, эв санааны нэгдлээ илэрхийлэн нэгтгэх зорилгоор хамба лам С.Гомбожав Улаанбаатар хотноо Балба, Монгол, Шри-Ланка, Энэтхэгийн бурханы шашны томоохон зүтгэлнүүдийн уулзалт хийлгэж, энэ үндсэн дээр 1970 онд Улаанбаатар хотноо Балба, Вьетнам, ЗХУ, Малайз, Монгол, Сингапур, Шри Ланка, Энэтхэгийн буддын шашилтын төлөөлөгч - нэрт зүтгэлтнүүд хуран чуулж, Азийн буддистуудын энх тайвны бага хурлын үндсийг тавьсан юм.

Тус байгууллагыг үндэслэгчид нь Монголын их ламтан С.Гомбожав, ламтан Д.Дагвадорж, ламтан Данзан, профессор Ч.Жүгдэр, Энэтхэгийн их ламтан Жинаратана, их ламтан Бакула, их ламтан Арьянаванса, Балбын их ламтан Амритананда, их ламтан Чечу Кушью, Шри Ланкийн их ламтан Суманатисса, их ламтан Индаратана, их ламтан Випуласара, их ламтан Маханама, ЗХУ-ын их ламтан Ж.Гомбоев, их ламтан Эрдынеев, профессор С.Д.Дылыков, Японы их ламтан Накаяма, Вьетнамын их ламтан Тхич Там Ан, их ламтан Тхич Дан Хау, Малайзын ноёнтон Ху Леон Хун, Сингапурын хатагтай Пат Чин Хуй нар байлаа.

АБЭТБХ түүхэн явцдаа энх тайвны төлөө тэмцэгч буддистуудын олон нийтийн хөдөлгөөн болон өргөжин хөгжиж, олон улсын төрийн бус байгууллагын хувьд дэлхийн тавцан дээр нэр хүнд нь өсөн бэхжиж ирсэн байна. АБЭТБХ Ази тивийн сонгодог буддизм дэлгэрсэн голлох орнуудад үндэсний төвтэй бөгөөд тус хөдөлгөөнд одоогоор Балба, Бангладеш, Вьетнам, Камбож, Лаос, Монгол, Орос, Сингапур, БНАСАУ, Өмнөд Солонгос, Тайланд, Шри Ланка, Энэтхэг, Японы буддистууд хамрагдаж байна. Далай ламтаны шашин, соёлын хэрэг эрхлэх зөвлөл, Япон дахь Солонгос иргэдийн буддын холбоо энэ хөдөлгөөнд мөн идэвхтэй оролцож байна.

Монголын бурханы шашинтан нар тус хөдөлгөөнд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн юм. АБЭТБХ-ын ерөнхийлөгч (хамба лам С.Гомбожав, Х.Гаадан) болон ерөнхий нарийн бичгийн дарга (доктор Ч.Жүгдэр, Г.Лувсанцэрэн) дан Монголоос сонгогдон хөдөлгээний эрхийг барьж, гол үйл ажиллагааг хариуцан удирдаж ирсэн билээ. Одоо дэд ерөнхийлөгчөөр Д.Чойжамц, Ч.Дамбажав, ерөнхий нарийн бичгийн даргаар Т.Булган ажиллаж байна.

АБЭТБХ анх үүссэн цагаас түүний Удирдах төв нь Улаанбаатар хотод байрлаж ирсэн, "АБЭТБХ-ын байнгын Удирдах төв Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлана" гэж АБЭТБХ-ын дүрэмд албан ёсоор баталгаажуулсан байдаг<sup>1</sup>.

Ийнхүү Монголын бурханы шашинтууд Азийн бурханы шашинты олон улсын нэгэн байгууллагыг хэрэг дээрээ тэргүүлэх болж, Монгол орон олон улсын буддын шашны нэг төв нь болсон билээ. Нөгөө талаар АБЭТБХ-ын үйл ажиллагааг тэргүүлэн тус хөдөлгөөнд идэвхтэй сролцсоноороо

<sup>1</sup> Азийн буддистуудын энх тайвны бага хурлын Дүрэм. VII чилд

монголын бурханы шашинтнууд дэлхийн тавцанд гарч, олон улсын шашны хөдөлгөөн, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох болсон юм.

Азийн буддистуудын энх тайвны хөдөлгөөний хөгжил, бэхжилт нь монголын буддистуудын олон улсын үйл ажиллагаатай салшгүй холбоотой юм. Уг хөдөлгөөний тухай өгүүлэхэд монгольн буддистуудаас явуулсан гадаад үйл ажиллагаа, түүний үр дүнгийн тухай өгүүлэхгүй байхын нөхцөлгүй болно.

АБЭТБХ-ын эрхийг барих дээд байгууллага болох ерөнхий бага хурал тус байгууллагын түүхэнд 10 удаа хуралдаад байгаагийн тав нь (I, V, VI, VIII, IX) Улаанбаатар хотод болжээ. Хурал хаана + боллоо гэсэн түүний гол илтгэлийг байгууллагын удирдлагад ажиллаж буй монголчууд тавьж, баримт бичгүүдийг боловсруулж, хөдөлгөөний чиг шугам, зэлжит зорилтуудыг тодорхойлон хэлэлцүүлдэг. Байгууллагынхаа зорилтыг тодорхойлон ерөнхийлөгч хамба лам С.Гомбожав хэлэхдээ: "АБЭТБХ бол энх тайван, шударга ёсыг дэлгэрүүлэх, хүний эрхийг хэмгаалахын төлөө Бурхан багшийн шавь нарын итгэл найдвар, чин эрмэлзлэлийг илэрхийлэн өөрөө оргилон гарсан Азийн бурханы шашинтны энх тайвны хөдөлгөөн юм. Тус хөдөлгөөн ялж төгс нөхцөн Бурхан багшийн энх амгалангийн тухай сургаалыг нийтэд хэрэгжүүлэхийг зорин Азийн бурханы шашинтны энх тайвны хөдөлгөөн болон хувирсан, цаг үеэ үнэнхүү олсон, хэв заншил, уламжлал ёсноо нийцсэн, бодит чухал үйл явц мөн гэж би үзэж байна" гэжээ<sup>1</sup>

Монголын бурханы шашинтны тэргүүлэнгүй оролцоо, тус хөдөлгөөнд оролцож буй олон орны бурханы шашинтны хамтын чармайлтаар Азийн буддистуудын энх тайвны бага хурал нь энх амгалан, шударга ёсны төлөө нийтийн ариун үйлсийн тусын тулд бурханы шашинтнуудыг нэгтгэх, буддистууд болон нийт шашинтнуудын хооронд харилцан итгэх, бие биеэ ойлгох уур амьсгал бий бөлгох үйлсэд чухал үүрэг гүйцэтгэж, Азийн буддистуудын дунд нэр нөлөө нь өндөржсөн юм. АБЭТБХ НҮБ-ын эдийн засаг, нийгмийн зөвлөл болон ЮНЕСКО-д статустай олон улсын нэр нөлөө бүхий төрийн бус байгууллага болон өсөж бэхжсэн юм.

Монголын бурханы шашинтан нар, түүний төв Гандантэгчэнлин хийдийн гадаад үйл ажиллагаа нь ийнхүү Азийн олон орны буддистуудтай бурханы номын ёсны найрсаг харилцаа тогтоон хөгжүүлэх, тэдний хамтын

ухаан, санаа сэтгэл, хүчин чармайлтыг бүх нийтийн энх тайван, эв зохицлын үйлсэд зангидан чиглүүлэхэд чиглэж, ийнхүү тодорхой үр дүнд хүрсэн юм.

Монголын бурханы шашинтнууд АБЭТБХ болон олон улсын шашны бусад байгууллагуудын шугамаар орон орны буддистууд хийгээд бусад шашинтнуудтай олон талын хамтын ажиллагаа тогтоон хөгжүүлэхийн зэрэгцээ Энэтхэг, Шри Ланка, Япон, Орос, Вьетнам, Лаос, Балба, Тайланд, Солонгос, Камбож, Бангладеш, Сингапур зэрэг орны бурханы шашинтнуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг улам идэвхжүүлэн гүнзгийрүүлж ирсэн билээ.

Азийн буддистуудтай тогтоосон холбоо, хамтын ажиллагааны талаар ярихдаа бид Төвдийн бурханы шашинтны тэргүүн Дээрхийн Гэгээнтэн Далай ламын Энэтхэгийн Дарамсала дахь төвтэй шашин, соёлын нэлээд зузаан хамтын ажиллагаатай явж ирснийг зүй ёсоор өгүүлэх ёстой. Монгол оронд XIV Далай лам анх чухамхүү АБЭТБХ, Гандан хийдийн шугамаар 1979 онд заларч, түүнээс хойш удаа дараа айлчлан ирж байна. Далай багш бидэнд ариун сургаалаа айлдаж, Монгол газар бурханы шашныг ариунаар мандуулан хөгжүүлэхэд онцгой сэтгэл тавин тусалж байдаг юм. Далай ламтаны дүрвэлтэд буй Засгийн газрын шашин, соёлын хэрэг эрхлэх зөвлөл, монгол, төвдийн бурханы шашинтны хамтын ажиллагаанд гол үүргийг гүйцэтгэж ирсэн юм. Дарамсала дахь Дээрхийн Гэгээн Далай ламтаны төвд Шашны дээд сургууль төгссөн олон лам нарыг илгээж, буддын төрөл бүрийн мэдлэг, ухаанд суралцуулан, номын мэдлэг, мэргэжлийн хүрээг өргөтгөн гүнзгийрүүлж ирлээ. Манай орны голлох сүм хийдийн шашны сургалтад төвдийн мэргэжилтэн багш нарыг Дарамсалагаас урин авчирч, хичээл заалгаж байна. Шашин, номын энэ харилцаа өнөөдөр улам өргөжин гүнзгийрч байна.

Монголын буддистууд мөн бурханы шашны олон улсын бусад байгууллага, бусад шашны байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдний үйл ажиллагаанд оролцож, холбоо харилцаагаа өргөжүүлж ирсэн билээ.

Үүнд бид юуны өмнө Дэлхийн буддын холбооны (ДБХ) тухай дурдах ёстой. ДБХ нь анх Шри Ланкагийн нэрт пали судлаач эрдэмтэн доктор Малаласекерагийн санаачилгаар Коломбо хотноо 1950 онд байгуулагдсан юм. Энэ нь Буддын тооллын 2493 он болно. ДБХ-ны Удирдах төв 1950-1958 онд Коломбод (Шри Ланка), 1958-1961 онд Рангунд (Бирма, эдүгээгийн Мьянмар), 1962 оноос Бангкокт (Тайланд) тус тус төвөлж ирээ. ДБХ нь дэлхийн нийт буддистууд, тухайлбал Ази, Европ, Хойд Америкийн бурханы шашины төлөөлөгчдийг эгнээндээ багтаасан, бурханы шашины бүх

урсгал, чиглэлийг хамарсан байгууллага юм. Дэлхийн буддын холбоо нь гишүүн байгууллагаар Бурхан багшийн сургаалтыг нарийн чанд сахиулан дагаж мөрдүүлэх, бурханы шашины эв нэгдэл, нягтрал, ах дүүсэг ёсыг бэхжүүлэх, хүн төрөлхтний тусын тулд зориулагдсан нийгэм, соёл, боловсрол зэрэг бүхий л үйл хэргийг зохион байгуулж гүйцэтгэх, хүн төрөлхтнийг энх амгалан, эв найртай байлгахын төлөө, хамаг амьтныг амар жаргалтай байлгахын төлөө чармайн зүтгэж, энэ үйлсийг эрхэмлэн буй бусад байгууллагатай хамтран ажиллахыг зорилт болгодог юм. Монголын бурханы шашинтнууд ДБХ-ны гишүүн болоод зогсохгүй, 1970-аад оноос тус байгууллагын дэд ерөнхийлөгчийн сонгуультайгаар (профессор Ч.Жүгдэр, проф. Д.Ичинхорлоо, хамба лам Ч.Дамбажав нар дэд ерөнхийлөгчөөр сонгогдсон) ажиллаж байгаа юм. Энэ нь дэлхийн буддистуудын дунд манай бурханы шашинтны нэр хүнд багагүй болохыг хасуулж байна.

Дэлхий нийт, түүний дотор Монгол оронд 90-ээд оноос өрнөсөн ардчилсан өөрчлөлт нь монголын бурханы шашинтнуудын гадаад харилцаанд ч мөн шинэчлэл оруулсан билээ.

Олон улсын тавцанд буддистуудтай бурханы номын болон энх тайвны үйлсийн төлөө хамтын ажиллагаагаа улам идэвхжүүлэх нь монголын бурханы шашинтны номын ёсны ариун үүрэг хэвээр байна.

Олон улсын хэмжээний бурханы шашинтнууд оролцдог байгууллагын тухайд бол Японы бурханы шашинтан хар хүмүүсийн хоёр том байгууллага болох Риши Косейкай, Сока Гаккайгийн тухай болон тэдгээртэй монголын бурханы шашинтнууд ямар нэг хэмжээгээр хслбоотой явж ирсэн бөгөөд Риши Косейкайгийн (түүний анхны ерөнхийлөгч Н.Ниваногийн) үндэслэсэн дэлхийн шашин, энх тайвны бага хурал (World Conference on Religion and Peace) ДШЭТБХ нь дэлхийн бүх тив, олон орны янз бүрийн шашинтныг эгнээндээ нэгтгэж, шашин хоорондын эв нэгдлийг тогтоож бататгах, энх тайван, хүн зоны сайн сайхны төлөө хамтын чармайлтыг илэрхийлэн нэгтгэх зорилго бүхий байгууллага юм. Түүнд бурханы шашин, христийн хийгээд исламын шашин, хинду, иудай, синто, бахай зэрэг олон шашинтны төлөөлөгч оролцдог. Японы бурханы шашинт хар хүмүүсийн байгууллага болох Риши Косейкай, түүний ерөнхийлөгч Н.Ниваногийн санаачилгаар анх үүссэн тус байгууллагыг Япон, Өмнөд Солонгос, АНУ, Англи, Энэтхэг зэрэг орны шашинтнууд тэргүүлэх үүрэгтэйгээр оролцож ирсэн юм. 1990 оноос хойшхи хугацаанд ДШЭТБХ-ын зүгээс ч монголын бурханы шашинтнуудтай хамтран ажиллаж, өөрийн хөдөлгөөндөө орогцуулахыг идэвхтэй дэмжиж

байгаа юм. 1995 онд тус ДШЭТБХ-ын дэд ерөнхийлөгч, модератор Ч.Хан тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлан, өөрийн хөдөлгөөний зорилго, үйл ажиллагааны тухай танилцуулж, монголын бурханы шашинтнуудыг хамтын үйл ажиллагаанд дааидэвхтэй оролцуулах талаар болон АБЭТБХ-д багтан ордог Зүүн өмнөд Азийн орнуудын бурханы шашинтнуудыг ДШЭТБХ-ын үйл ажиллагаанд оролцуулж, хамтран ажиллахад нь зуучилж дэмжих талаар хэлэлцэн тохиролцсон юм. Энэ үндсэн дээр хамтын ажиллагаа идэвхжиж, түүнчлэн Лаос, Камбож, Вьетнам, Оросын бурханы шашинтны төлөөлөгчид ДШЭТБХ болон Азийн ШЭТБХ-ын хурал чуулгануудад оролцох зэргээр холбоотой болж ирсэн билээ.

ДШЭТБХ-ын Азийн салбар байгууллага болох Азийн шашин, энх тайвны бага хурлын (АШЭТБХ) манай бурханы шашинтнууд нэгэн адил оролцож ирлээ. АШЭТБХ нь олон шашны хамтын ажиллагаа, хамтын шашны үйлсэд тулгуурлан дэлхий дахин, тухайлахад Ази тивийн энх тайвныг бэхжүүлэн бататгахыг зорилт болгосон Ази, номхон далайн сав нутгийн олон шашинтан, сүсэгтнүүдийн бүс нутгийн бие даасан байгууллага юм гэж дүрэмдээ заасан байдаг. Энэ зорилго нь Ази дахины шашны уламжлал, дурсгалыг хадгалах, бэхжүүлж арвижуулах, энх тайван, шударга ёс, хүний хүнч чанарын төлөө шашинтнуудын бүтээлч, шүүмжлэлт чармайлтыг хөгжүүлэн бататгах зорилтоор хэрэгжинэ хэмээн үзэж, үйл ажиллагаагаа чиглүүлж байгаа болно.

Иймд тус байгууллагын үйл ажиллагаанд монголын бурханы шашины төлөөлөгчид цаашид ч улам идэвхтэй оролцоход харшлах шалтгаангүй юм. Тус байгууллагын удирдлагад байгаа байр сууриа улам бэхжүүлэн өргөжүүлж, зарим арга хэмжээг эх орондоо хүлээж авч, зохион байгуулж ч болох юм.

Сока Гаккай бол анх 1920-иод оны үеэс үүссэн, тэр үедээ Японы нийгмийн нэгэн оппозици байгууллага байжээ. Тус байгууллага Японы Ничирэн чиглэлийн буддизмын философи, үзэл санааг үйл ажиллагааныхаа үндэс болгодог. Сока Гаккай одоо өөрийн харьяандаа хүүхдийн цэцэрлэг, дунд сургуулиуд, их сургууль, судалгааны хүрээлэнтэй томоохон цогцолбор байгууллага болоод байна. Олон улсын харилцааны хувьд бол, улс үндэстнүүдийн харилцан ойлгох, итгэлцэх, соёлын талаар хамтран ажиллахыг урьдал болгож, энэ үндсэн дээр олон улсын энх тайван, соёл, боловсролын хамтын үйлсэд хувь нэмрээ оруулахыг зорилт болгодог байна. Ялангуяа өөрийн гуравдахь буюу одоогийн ерөнхийлөгч Д.Икедагийн үед гадаад үйл ажиллагааг идэвхтэй явуулж, Олон улсын Сока Гаккайг (Soka

Gakka International) байгуулан ажиллаж байна. Үүнд Ази, Европ, Латин Америкийн нэлээд орон хамарагддаг гишүүн байгууллага бүхий орнууддаа хүмүүнлэгийн тусlamж дэмжлэг үзүүлэхэд баагүй анхаардаг юм. Олон улсын Сока Гаккай байгууллага эгнээгээ өргөтгөх, түүний дотор манай орны бурханы шашинты төлөөллийг эгнээндээ багтаахыг эрмэлзэж байгаа болно. Олон улсын Сока Гаккайн зарим арга хэмжээнд манай буддистууд 1980-аад оны дунд үеэс нэлээд оролцох болсон ба одоо манайд Олон улсын Сока Гаккайн монголын төв байгуулагдаж эхэлж байна.

Харин Сока Гаккай улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог бөгөөд Комета намын бодлогыг баримталдаг, Японы улс төрийн үйл ажиллагаанд нөлөөлдөг зэрэг онцлог байдалтай гэж Японы бурханы шашны байгууллагууд үздэгийг бид түүнтэй харилцахдаа харгалзан үзэхэд илүүдэхгүй.

Өмнөд Солонгост АНУ-ын бодлого, нөлөөгөөр Христийн шашин хүчтэй түрэн оржээ. Өмнөд Солонгос ядуу зүдүү байдлаасаа гарч чадсан сүүлийн үед БНСУ-д уламжлалт бурханы шашнаа улам сэргээн идэвхжүүлэх, түүнд анхаарлыг төвлөрүүлэх хэндлага давамгайлах болж байна. Өмнөд Солонгосын бурханы шашинтнүүд хоёр том байгууллагад хуваагддаг. Түүний Чоэгү (Choe gue) чиглэл нэлээд нөлөөтэй юм. Тус чиглэлийн лам нарын төлөөлөгчид Монголд зочилж, АБЭТБХ-ын гишүүнээр ч элсэж байв. Ер нь Солонгос бол сонгодог бурханы шашины уламжлалт орон бөгөөд Юань гүрний үед ч монголчууд Солонгосыг эзэлж, солонгосын хан хүүд Монгол гүнж өгч байхад, бурханы шашин төвдийн буддизмын хэлбэрээр нөлөөлж байсан баримт бий. Эдүгээ солонгосын (БНСУ-ын) буддистууд монголын бурханы шашинтнуудтай холбоо тогтооход ч мөн анхаарал тавьж байна.

Ер нь Солонгосын бурханы шашинтнууд Монголд нөлөөлөхөд анхаарч зарим алхмыг хийж эхэллээ. Христийн шашныг монголчуудын дотор нэвтрүүлэх ажлыг гадаадаас нэгдсэн бодлоготойгоор явуулж байгаа бөгөөд энэ бодлогыг хэрэгжүүлэхэд Солонгосын христосс шашинтнууд голлох үүрэгтэйгээр ажиллаж байна. Ийм нөхцөлд Солонгосын бурханы шашинтнуудаас Монголд идэвхжүүлж байгаа шашины үйл ажиллагааг дэмжих нь зүйтэй юм гэж бид үзэж байна.

Гадаад орнууд, ялангуяа Солонгосын бурханы шашинтнуудтай холбоо тогтоон, харилцаа хамтын ажиллагаа хөгжүүлэх чиглэлээр диссертаци бичигчийн толгойлж буй Дашчойлин хийд нэлээд ажил өрнүүлж

ирлээ. Тухайлан хоёр талын хамтын ажиллагааны тухай дурдахад, тус хийд Чөгэ ордериин буддистуудтай нэлээд зузаан холбоо тогтоож, эл чиглэлийн том ламтан Хвал Ан Хан (монголчууд Хваран хэмба гэж нэрлэдэг болжээ) хамба, түүний сүм хийтэй нэлээд жил хамтран эжиллаж, тодорхой үр дүнд хүрч байна. Их ламтан Хвал Ан Хан бол дэлхийн олон оронд бурханы шашныг сэргээн хөгжүүлэх, Бурхан багшийн ариун сургаалыг дэлгэрүүлж сурталчлах, тухайн орны эмзэг бүлгийн хүмүүст гуслах талаар их зүйл хийж байгаа энэрэнгүй үзэлтэн юм. Бидний хамтын ажиллагааны хүрээнд сүүлийн жилүүдэд Монгол оронд Солонгосын бурханы шашны сүм байгуулан хүүхэд залуучуудад Бурханы сургаалыг тайлбарлан таниулах, манай талаас залуу лам нарыг Солонгост өөрийн зардлаар аван магистр, докторын сургалтад сургах ажлыг хийж байна. Бидний хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу ийм сургалтыг цаашид ч явуулах ба хоёр орны сүсэгтэн олонд Монгол, Солонгосын буддизмыг таниулах, хамтарсан мөргөл хийх, хурал семинар зохион байгуулах, ном хэвлэх зэргээр ажиллаж байна.

Их ламтаны сүүлийн үед бүтээсэн нэг ажил нь Зайсанд баригдаж буй цогцолборт бүтээсэн Бурхан багшийн сүрлэг сайхан сэргэ дүр юм. Энэ дүр нь сэтгэлийн их амарлингүй, ариуслыг бэлгэдэн илэрхийлж, хүмүүсийн зүрх сэтгэлд шимлэн амьдарч буй бурхан болж, дотсад ариун сэтгэл, бурханлаг чанарыг илтгэж, хүн зон, улс үндэсний ариусал, хөгжил дэвшилд хүч өгөн дайчлан дуудагч болгохоор бүтээгдсэн билээ. Бурханы дүрийн нээлтийн ёслол дээр их ламтан Хвал Ан хамба хэлэхдээ: 'Хэрэв бид Бурхан багшийн сургаалыг даган мөрдөж ахмадаа хүндлэн, эх дүү нараа энэрч, айл хөршийнхөнтэйгээ (бусадтайгаа) эв найртай байх аваас бид Бурхан багшийг дууриан дагасан бодгаль болно. . . Монголын их хутагт Занабазар амьдралынхаа туршид Бурхан багшийн үлгэрийг даган мөрдсөн гэгээнтэн байжээ. . . Одоо Зайсангийн ууланд дүрийг нь бүтээн босгож байгаа. Бурхан багш бидэнд их амарлингүйн мөрийг заан сургах, хүн төрөлхтөн гэдэг ер нь ямар байх учиртайн үлгэр дууриалыг үзүүлсэн юм" гээд, энэ бүхэн бол Монголын төлөө хийгдсэн, "энд ирж чин сэтгэлээсээ үнэний дуу хоолойг сонсогч хэн бүхэн монголын нийгмийн төлөө үнэнхүү буян үйлдэгч болно" гэсэн юм.

Ийнхүү бурханы шашинтны хамтын ажиллагаа нь Монгол оронд бурханы шашныг улам сэргээн хөгжүүлэх, нийгэмд түүний үзүүлэх үүрэг нөлөөг бэхжүүлэхэд тустай үйлс болж байна хэмээн бодож байна.

Эцэст нь Дэлхийн буддын холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирсэн уламжлалаа хөгжүүлэхийн чухлыг дурдъя. ДБХ ч үйл

## МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

ажиллагаандаа шинэчлэл хийх талаар мөн нэлээд анхаарч байна. Үүнд үндэсний буюу орон нутгийн төвүүдийн шашин номын болон нийгэм, соёлын үйл ажиллагааг илүү чөлөөтэй байлгах, буддистуудын номын болон практик үйлдлийн үзэл бодол, туршлагыг солилцох чигийг гол болгон ажлаа өрнүүлэх, эв нэгдлийг бэхжүүлэх, мөн олон угс, бус нутгийн ба үндэсний хэмжээнд зохиож буй нийгэм-хүмүүнлэгийн болон соёлын арга хэмжээ үр дүнтэй оролцохыг чухалчилж байна. ДБХ-ны дэргэд Дэлхийн буддын их сургуулийг (БШИС) 2001 оноос байгуулан ажиллуулж эхлээд байгаа нь Бурхан багшийн сургаалыг сурч эзэмших, судлах, номлож дэлгэрүүлэх, энэ талаар бурханы шашинтнуудын хамтын ажиллагааг өрнүүлэхэд нэн чухал үйлс болж байна. Эдүгээ бид тус Их сургуулийн Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байгаа бөгөөд цаашид БШИС-тэй холбоо харилцаагаа улам бэхжүүлэх аль аль талдаа ашигтай, үр дүнтэй болох юм.

Бид цаашид ч ДБХ-ны болон олон улсын бусад буддын байгууллагын үйл ажиллагаанд улам идэвхтэй оролцох чиг бодлогыг тууштай баримталж байна. ДБХ-ны шугамаар зохиогдох тодорхой арга хэмжээг эх орондоо авч хийх талаар бodoх цаг болсон гэж үзнэ.

Эл бүхэн бол ийм хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэн, түүнд манай бурханы шашинтнууд улам идэвхтэй оролцохын чухлыг харуулж байна.

Өнөөдөр манай шашны байгууллага, сүм хийдүүдээс явуулж байгаа гадаад харилцаа улам идэвхжиж, олон талыг хамарч байна. Эл хамтын ажиллагаа шашин-номын үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй, мөн нийгэм, соёлын хүрээг хамарч, арга хэлбэр нь баяжин, сүсэгтэн болон ерөөс хүн ардын амьдрал, сэтгэл, ухамсарт тодорхой нөлөө үр дүнтэй болж байна. Ийм нөхцөлд хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг улам идэвхжүүлэх, орчин үеийн шашин, номын үйл ажиллагааны янз бүрийн хэлбэр, арга, боломжийг судалж хэрэгжүүлэх нь гадаад хамтын ажиллагаанд нөлөөлөөд зогсохгүй, дотоодын шэшин номын үйл ажиллагааг олон талтай болгож, зохих хэмжээний шинэтийн хийх, өнөөгийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд ч чухал ач холбогдолтой юм.

Энэ бүхэн нь шашны плюрализмын өнөөгийн нөхцөлд уламжлглт бурханы шашинаа хадгалан бэхжүүлэх, нэр нөлөөг нь дээшлүүлэхэд, цаашлаад манай улсын олон улсын нэр хүндий-бэхжүүлэх нэг сэжим болж, мөн үндэсний эв нэгдлийг ханган бататгах, соёл, зан заншлын өвөрмөц төрхөө хадгалахад ч чухал юм гэж үзэж байна.